



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/76

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын "Газрын тухай хууль"-ийн 30 дугаар зүйл 30.2, 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалтууд, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт /Хуучин ХААН банкны өмнө 111-р байрны урд талд / байршилтай 18 м.кв /0,0018 га/ гражийн зориулалттай газрыг эзэмшигч иргэн Сумъяа овогтой Цэрэн-Очир /ЗЮ:77021519/ нь 2016 оны 04 дугаар сарын 21-ны өдөр нас барсан тул эзж Сампил овогтой Цэрмаа /ЗЮ:53030101/-д газрыг зориулалтаар шилжүүлж 25 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 11 сарын 05-ны өдрийн А/591 тоот захирамжийн иргэн С.Цэрэн-Очир-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000426109 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200242